

ӨМНӨХ ҮГ

Дугаарын эхэнд сэтгүүлийн редакцийн зөвлөлийн эрхэм гишүүд Ононгийн Төмөртогоо, Альфред Крёнер нарын дурсгалыг хүндэтгэж байна.

Монголын Геосудлаач сэтгүүлийн редакцийн зөвлөлийн идэвхтэй, хүндэт гишүүдээр ажиллаж, сэтгүүлийн чанарыг олон улсын түвшинд хүргэхэд мэдлэг оюунаа зориулж байсан Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич, Алдарт геологич, геологи-минералогийн шинжлэх ухааны доктор, салбарын манлай эрдэмтэн, профессор Ононгийн Төмөртогоо, Германы Майнз их сургуулийн хүндэт профессор, IGCP-662 олон улсын геологийн хөтөлбөрийн “Аккрецаас коллиз хүртэл царцдасын үүсэл хөгжил ба орогены тогтоц” төслийн удирдах зөвлөлийн гишүүн, Бээжингийн SHRIMP Төвийн тэргүүлэх судлаач, хүндэт профессор, олон улсын Гондвана судалгааны холбооны зөвлөх гишүүн, профессор Альфред Крёнер нар 2019 оны 5 сард таалал төгсөж, Дэлхийн ба Монголын геологийн шинжлэх ухаанд нөхөж баршгүй гарз тохиолдлоо.

Академич О.Төмөртогоо тектоникийн чиглэлийн судалгааг хөгжүүлж, түүний зохиосон ба удирдлагаар нь гүйцэтгэсэн олон тооны геологийн ба тектоникийн зургууд Монгол орны болон Азийн геологийн шинжлэх ухааны практикт томоохон ололт болсон.

Академич О.Төмөртогоо, профессор А.Крёнер нар Төв Азийн ороген бүсийн судалгаанд үүний дотор Монголын геологийн судалгаанд ихээхэн хувь нэмэр оруулсан эрдэмтэд юм. Тэдний мэргэжлийн түвшин, ур чадвар, геологийн мэргэжилдээ үнэнч шударга, өндөр хариуцлагатай, тусархуу сайхан шинж чанар хамт ажиллаж байсан бидний зүрхэнд үлдэх болно. О.Төмөртогоо, А.Крёнер нарын Дэлхийн ба Монголын геологийн салбарт оруулсан оюунлаг хувь нэмэр, олон зуун бүтээлүүд нь ач холбогдолоо алдахгүй үлдэж, шинэчлэгдэн баяжиж, шинэ бүтээлүүдийн эхлэл болж үлдэнэ гэдэгт итгэж байна.

Монголын Геосудлаач сэтгүүлийн редакцийн зөвлөл

Монголын Геосудлаач сэтгүүлийн шинэ дугаарыг Та бүхэнд хүргэж байна. Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт, геологи, тектоник, палеонтологи, геодезийн чиглэлийн судалгааны материалууд хэвлэгдэж байна.

Сэтгүүлийн чанарыг сайжруулахад цаг заваа гарган ажилласан сэтгүүлийн эрхлэх зөвлөлийн гишүүд, редакцийн зөвлөлийн гишүүд, уригдсан шүүмжлэгч нарт талархсанаа илэрхийлье. Та бүхний хичээл зүтгэлийн үр дүнд Mongolian Geoscientist сэтгүүл нь JPPS (Journal Publishing Practices and Standards) олон улсын байгууллагын хөндлөнгийн үнэлгээгээр “Нэг Од” -ны болзол хангасан сэтгүүл гэж үнэлэгдсэнийг дуулгахад таатай байна.

Эрхэм хүндэт геологичид, судлаачид, зохиогчид, уншигчид та бүхнийг бүтээлээ Mongolian Geoscientist сэтгүүлд хэвлүүлж, олон улсын түвшинд судалгааны үр дүнгээ түгээн дэлгэрүүлэхийг урьж байна.

Сэтгүүлийн зөвлөлөөс сэтгүүлийн чанар, үр өгөөж, нэр хүндийг сайжруулахын төлөө хичээн ажиллах болно.

Ерөнхий редактор
Б.Батхишиг

Эрхлэх зөвлөлийн гишүүд:
Б.Мөнхцэнгэл, Б.Алтанзул, Х.Цэдулам